



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2020 оны 01 сарын 17 өдөр

Дугаар A/06

Булган

Хязгаарлалт тогтоох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6.л, Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.1, 6.2.5, 8 дугаар зүйлийн 8.4.3, Тариалангийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.12, 27 дугаар зүйлийн 27.1, 27.2, 27.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тариалангийн хөрсний үржил шимийг хадгалах, улаан буудайн тариалалтыг нэмэгдүүлэх зорилгоор тосны ургамлыг үр тариа тариалах нийт талбайн 10 хувиас хэтрүүлэхгүй тариалж байх арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

2. Тосны ургамал тариалах талбайн хөрсний агрохимийн шинжилгээг хийлгэж, хөрсний төлөв байдал, чанарын өөрчлөлтөд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг дарга нарт даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга /Ч.Амгалан/, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Ү.Бямбасүрэн/ нарт тус-тус чиглэл болгосугай.



З.БАТЗОРИГ